

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

- Санамж: 1. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
2. Сонгох даалгавраас зөвхөн нэг хариултыг сонгоорой.

1. Нийгэмшлийн субъектив талд аль нь хамаарах вэ? /1 оноо/
 А. Нийгэмшил нь соёлыг нэг үеэс нөгөө үед дамжуулан өвлүүлэх үйл явц
 В. Нийгэмшил нь бие хүний хөгжил төлөвшлийн үйл явцын нэг бүрэлдэхүүн хэсэг.
 С. Нийгэмшлээр чухам хэнээс хэнд соёл, туршлага, үнэт зүйлс уламжлагдаж байгааг илэрхийлнэ.
 D. Нийгэмшлээр өөриймшүүлж буй соёл, туршлага, үнэт зүйлсийг илэрхийлнэ.
 E. Нийгмийн соёл, туршлага, үнэт зүйлсийг хэрхэн яаж өөриймшүүлэх арга замыг илэрхийлнэ.
2. Нийгмийн гажуудлын төрөлд аль нь орох вэ? /1 оноо/
 А. Жагсаал цуглаан хийх В. Үр хөндүүлэх С. Биеэ үнэлэх
 D. Шоронд хоригдох. E. Байцаалт өгөх
3. ... нь хувь хүн нийгмийн амьдралд орж, нийгмийн гишүүдийн эрхэмлэдэг хэм хэмжээг өөриймшүүлэн, нийгмийн харилцаанд оролцоход сурах, сургах үйл явц юм. /1 оноо/
 А. Бие хүн болох В. Хүмүүжил С. Төлөвшил
 D. Боловсрол E. Нийгэмшил
4. Нийгэмшлийн гол хүчин зүйлсийг тоочихдоо илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? /1 оноо/
 А. Гэр бүл В. Нийгмийн үнэт зүйл С. Үе тэнгийнхэн
 D. Сургууль E. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл
5. Зөв харгалзуулна уу. /1 оноо/
 1.Полиандр а.Гэрлэсэн хосууд эхнэрийнхээ эцэг эхийн гэрт амьдрах хэлбэр
 2.Полигени b.Олон нөхрийн дундаас хүүхдийн эцэг нь тоглоомон нум сум өргөж ёслоно.
 3.Матрилокаль с.Нийгэмд өндөр суурьтай эрчүүд олон эхнэртэй байх эрх эдэлдэг гэр бүл
 А.1b2a3c В.1b2c3a С.1c2b3a D.1a2b3c E.1c2a3b
6. Жолооч Батын хүү Буяа Японд мэргэжил эзэмшин, дэлхийд нэртэй компанид инженерээр ажиллаж байгаад монголдоо эргэн ирж, инженерүүдийг бэлтгэдэг коллежийн захирал болов. Энэ нь нийгмийн шилжих хөдөлгөөний аль хэлбэрт хамаарах вэ? /2 оноо/
 А. Үе хоорондын шилжих хөдөлгөөн В. Бүлгийн шилжих хөдөлгөөн
 С. Үеийн доторхи шилжих хөдөлгөөн D. Олдмол байр суурь
 E. Бүтцийн шилжих хөдөлгөөн
7. Улс орон хэмээх ойлголтын тодорхойлолт аль нь вэ? /2 оноо/
 А. Өөрийн гэх нутаг дэвсгэрийн хязгаар төр засаг, байгууллага бүхий тухайн нийгэм, хүмүүсийн бие даан оршин амьдарч буй онцлог нутаг
 В. Засаглал удирдлагын тодорхой дэг журам бүхий тухайн улс орон, нийгмийг удирдах улс төрийн цөм байгууламж
 С. Тодорхой улс орон ард түмний түүхэн хөгжлийн шатан дахь нийгэм улс төр эдийн засаг, соёлын тогтвортой хамтын ажиллагаа харилцан үйлчлэл,хэрэгцээ сонирхлын ялгаа зөрчилдөөн бүхий хүмүүсийн нэгдэл
 D. Нийгмийн хуучин байгуулал шинэ байгуулалд эрс шилжилт хийж, чанарын үсрэлтэнд хүрэх үйл явц
 E. Хүний амьдралын нөхцөл чанар дээшлэх гэх зэрэг томоохон хэмжээний эерэг үр дагаврууд
8. Эдийн засгийн баялгийн ялгаанаас үүдэлтэй нээлттэй буюу хувийн байр сууриа өөрчлөх боломжтой давхраажилтын хэв маяг аль нь вэ? /1оноо/
 А. Анги В. Каст С. Язгуур D. Боолчлол E. Нийгмийн ялгарал

9. Хүний өөрийнх нь хичээл зүтгэл чармайлтаар олж авдаг статус аль нь вэ? /1 оноо/
 А. Төрөлх статус В. Олдмол статус С. Хувь хүний статус
 D. Гол статус E. Заяагдмал статус
10. Нийгмийн халамж нь: -нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж; -нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээ гэсэн хоёр төрөлтэй. Нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээнд дараах өгөгдлүүдийн аль нь хамаарах вэ? /2 оноо/
 А. Олон хүүхэдтэй эхэд жилд нэг удаа олгоно.
 В. Нэн ядуу амьдралтай иргэн хамрагдана.
 С. Хүүхдийг 2 нас хүртэл асарсны төлөө сар бүр олгоно.
 D. Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авч өсгөсний төлөө улирал бүр олгоно.
 E. Жирэмсэн болон амаржсан эх хамрагдана.
11. “Байгаль дэлхийгээ хайрла, хог бүү хая, найрсаг бай, хулгай бүү хий” гэх мэтээр хүний биеэ авч явах ёсыг захирамжлан тогтоох нь ... юм. /2 оноо/
 А. Ёс суртахууны онцлог В. Ёс суртахууны шинж
 С. Ёс суртахууны нөлөөлөл D. Ёс суртахууны шаардлага
 E. Ёс суртахууны бэлгэ тэмдэг
12. Ёс суртахууны зохицуулах үүрэг аль нь вэ? /1 оноо/
 А. Хувь хүний үйл ажиллагааг бусад хүмүүс болон нийгмийн эрх ашигт нийцүүлэн чиглүүлж байдаг.
 В. Ёс суртахууныг өөриймшүүлснээр хүмүүс үйлдэл, үйл ажиллагаагаа хянаж удирдаж байдаг.
 С. Ёс суртахуунаар дамжин хүмүүс дүрэм, журам, үүргийнхээ талаар мэдлэг эзэмшдэг.
 D. Хүмүүс өөрийгөө авч явах чиг баримжаа эзэмшиж байдаг.
 E. Өөрийн болон бусдын ёс суртахууны төлөвшилд үнэлгээ өгч байдаг.
13. Зөвхөн өөрийн аж төрөх ёсыг зөв, өөр аж төрөх ёсыг хачин бүдүүлэг гэж үзэх нь ямар үзлийн илрэл вэ? /1 оноо/
 А. Релятивизм В. Соёлын шок С. Этноцентризм
 D. Универсализм E. Соёлын гажилт
14. Соёл шинэ үеийн хүмүүст мэдлэг туршлага олгоно. Энэ нь соёлын аль үүрэг вэ? /1 оноо/
 А. Мэдээллийн үүрэг В. Танин мэдэхүйн үүрэг С. Харилцааны үүрэг
 D. Төлөвшүүлэх үүрэг E. Хэм хэмжээний үүрэг
15. Дараах өгөгдлөөс аль нь зөв бэ? /2 оноо/
 А. Харилцааны явцад мэдээллийн 20-40 хувь нь үг яриагаар, 60-80 хувь нь дохио зангаагаар дамждаг гэж зарим судлаачид үздэг.
 В. Харилцааны явцад мэдээллийн 60 хувь нь үг яриагаар, 40 хувь нь дохио зангаагаар дамждаг гэж зарим судлаачид үздэг.
 С. Харилцааны явцад мэдээллийн 10 хувь нь үг яриагаар, 90 хувь нь дохио зангаагаар дамждаг гэж зарим судлаачид үздэг.
 D. Харилцааны явцад мэдээллийн 90 хувь нь үг яриагаар, 10 хувь нь дохио зангаагаар дамждаг гэж зарим судлаачид үздэг.
 E. Харилцааны явцад мэдээллийн 60-80 хувь нь үг яриагаар, 20-40 хувь нь дохио зангаагаар дамждаг гэж зарим судлаачид үздэг.
16. ... гэдэг үг нь “cultura”-латин хэлний “газар боловсруулах”, “хүмүүжил, хүндлэл” гэсэн утгыг илтгэдэг. /1 оноо/
 А. Соёл В. Дагуул соёл С. Нийтийн соёл
 D. Ардын соёл E. Урлаг
17. Монгол түмний бэлгэдлийн ойлголтоор цагаан өнгө нь цэвэр ариуныг, хөх өнгө өнө мөнхийг, улаан өнгө нь ялалтын бэлгэдэл бол шар өнгө юуны бэлгэдэл вэ? /2 оноо/
 А.Аз жаргал В.Үржин дэлгэрэх С.Арвин баялаг D. Мандан бадрах E.Амжилт
18. Хүмүүсийн итгэл үнэмшил, хандлага, сонголт харилцан адилгүй байдаг. Үүнд хамаарах ойлголт аль нь вэ? /2 оноо/
 А. Үнэлэмж В. Үнэлгээ С. Үнэлэмжийн баримжаа D. Үнэт зүйл E. Үнэн

19. Соёлыг антропологийн хандлагаар хэрхэн тодорхойлдог вэ? /3 оноо/
 А. Янз бүрийн ард түмний домог, аман зохиол зэрэг соёлын уламжлалыг харьцуулан судлах замаар тайлбарладаг.
 В. Соёлыг аливаа нийгмийн аж төрөх ёс, зохион байгуулалтыг бүрдүүлэгч хүчин зүйл гэж үздэг.
 С. Соёлыг хүний мөн чанарын илэрхийлэл болох талаас нь тайлбарладаг.
 D. Соёл нь хүний гэх зүйлийг амьтны гэх зүйлээс ялгах хязгаар болж өгдөг хэмээн үздэг.
 E. Соёл бол өв уламжлан авсан бүтээл, юмс, үзэл санаа, үнэт зүйл гэж тайлбарладаг.
20. Улс төрийн оролцоог олон нийт таашааж буй эсэхээс хамааруулан хэрхэн ангилдаг вэ? /1оноо/
 А. Идэвхтэй ба идэвхгүй В. Хуулийн хүрээнд, хууль бус С. Нийцтэй ба нийцгүй
 D. Сайн дурын ба албадлагын E. Ортодоксаль ба ортодоксаль бус
21. Засаглалын объектыг аль нь зөв тодорхойлж байна вэ? /2 оноо/
 А. Удирдан засаглах тэмүүлэлтэй, хариуцлага хүлээх болон зорилгоо хэрэгжүүлэх чадвартай, захирагдагсдадаа нэр хүндтэй
 В. Эрх мэдлийн идэвхтэй, хөтлөн чиглүүлэгч шинжийг агуулдаг бөгөөд өөрийн эрх мэдлийн хүрээнд засаглалын харилцааны агуулгыг тушаалаар дамжуулж тодорхойлдог.
 С. Нийгмийн бүлэг, нийт ард түмнийг шууд төлөөлдөг улс төрийн элит ба хошуучлагчид
 D. Улс төрийн засгийг гартаа авч, тогтоон барих, хэрэгжүүлэх бололцоо олгож байдаг хүчин зүйлс
 E. Удирдуулж буй иргэд, нийгмийн хэсэг бүлэг, байгууллага, нийгэм
22. Өгөгдлийг зөв харгалзуулсан хариултыг сонгоорой. /1оноо/
 1. Хуулийг биелүүлэх а. Дээд шүүх
 2. Хуулийг тогтоох b. Засгийн газар
 3. Хуулийн биелэлтийг хянах c. Улсын их хурал
 А. 1a2b3c В. 1b2a3c С. 1c2b3a D. 1a2c3b E. 1b2c3a
23. Аль нь оролцооны дэмжлэг вэ? /2 оноо/
 А. Сонгуульд саналаа өгөх
 В. Төрийн албанд ажиллах
 С. Цэргийн алба хаах
 D. Төрийн далбаанд хүндэтгэл үзүүлэх
 E. Татвар төлөх
24. Нэг намын тогтолцооны шинж аль нь вэ? /1оноо/
 А. Тухайн улс оронд засгийн эрх мэдлийг хүлээн авч хэрэгжүүлэх чадвартай хоёр нам давамгайлдаг.
 В. Төрийн эрх мэдлийг барьж, бусад нам хөдөлгөөнийг хориглодог.
 С. Сонгуульд ялагдсан нам нь сөрөг хүчин болно.
 D. Улс төрийн амьдралд хэд хэдэн нам идэвхтэй оролцдог
 E. Эрх мэдлийн төлөө өрсөлдөх боломжийг намуудад олгодог.
25. Сонгуулийн чөлөөтэй сонгох зарчимд хамаарах өгөгдөл аль нь вэ? /1оноо/
 А. Нас хүйс, яс үндэс, гарал угсаа, мэргэжил, хэл, санхүүгийн чадвараас үл шалтгаалан бүгд оролцох
 В. Сонгогч бүр ижил тооны санал гаргах эрхтэй бөгөөд санал бүр адил жинтэй байх
 С. Сонгогч ямар нэгэн дарамт шахалтгүйгээр гагцхүү өөрийн үзэмжээр саналаа өгөх явдал
 D. Сонгуулийн эцсийн үр дүн нь зөвхөн иргэдийн санал хураалтын үр дүнгээр шийдэгддэг.
 E. Сонгуульд оролцохдоо чөлөөт сонголтоо хийн, саналаа чөлөөтэй илэрхийлэх бүхий л бололцоогоор хангагдах ёстой.
26. Төрийн тэргүүн, засгийн газрын тэргүүний бүрэн эрхийг өөр өөр субъект буюу ерөнхийлөгч, ерөнхий сайд хадгалж, засгийн газрыг ерөнхийлөгч байгуулж парламентын өмнө хариуцлага хүлээдэг засаглалын хэлбэр аль нь вэ? /2оноо/
 А. Парламентын В. Холимог С. Ерөнхийлөгчийн
 D. Үндсэн хуульт хаант засаглал E. Хэмжээт эрхт хаант засаглал

27. Шууд ардчиллын давуу тал аль нь вэ? /1 оноо/
 А. Төрийн бодлого, шийдвэр боловсруулахад их хугацаа шаарддаг
 В. Нийгэмд улс төрийн тогтвортой байдал, дэг журмыг илүү хангадаг
 С. Улс төрийн хариуцлагыг өндөржүүлдэг
 D. Нийгэм улс төрийн тогтолцоог мэргэшсэн туршлагатай хүмүүс удирддаг
 E. Иргэдийн улс төрд оролцох идэвх, сонирхол өсдөг
28. Ардчилсан төрийн дэглэмийг холбогдох утгатай нь зөв харгалзуулна уу. /1 оноо/
 1. Либераль дэглэм А. Энгийн олон түмний засаглал гэсэн утгатай грек үг
 2. Консерватив дэглэм В. Эрх чөлөө гэсэн утгатай латин үг
 3. Охлократ дэглэм С. Хадгалах гэсэн утгатай франц үг
 А. 1a2b3c В. 1a2c3b С. 1b2c3a D. 1b2a3c E. 1c2b3a
29. Аль нь эрх зүйт төрийн шинжид хамаарах өгөгдөл вэ? /3 оноо/
 А. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхэд “Алдарт эх” одон, тэтгэмж олгодог.
 В. Эдийн засгийн зохистой бодлого явуулаагүйн улмаас засгийн газар огцров.
 С. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд хуулийн дагуу халамж, асрамж эдэлнэ.
 D. Гал түймрийн улмаас гэр оронгүй болсон иргэнд засгийн газраас тусламж олгов.
 E. Цалин, тэтгэврийн хэмжээг 50 хувиар нэмэх шийдвэр гарав.
30. Үйлдвэрлэлийн хэмжээнээс шууд хамааран гарч байдаг зардлыг.....гэнэ. /1оноо/
 А. Тогтмол зардал В. Үйлчилгээний зардал С. Шууд бус зардал
 D. Хувьсах зардал E. Аж ахуйн зардал
31. Компаний давуу тал аль нь вэ? /3 оноо/
 А. Хохирлыг гишүүд тэнцүү хариуцна
 В. Үүсгэн байгуулахад харьцангуй бага хөрөнгө шаардана
 С. Бага хэмжээний хуримтлалтай ч олон тооны хүмүүсийн хөрөнгийг нэгтгэх боломжтой
 D. Гишүүдийн шийдвэрийг харгалздаг тул харьцангуй бага эрсдэлтэй
 E. Хянах боломжтой, асуудлыг шийдэхдээ хурдан
32. Маркетингийг илэрхийлсэн ойлголт аль нь вэ? /1 оноо/
 А. Менежмент нь аж ахуй эрхлэн хөтлөх, жолоодох гэсэн утга бүхий англи үг
 В. Хэрэглэгчийн эрэлтийг судлан, түүнд тохирсон бараа үйлчилгээг зах зээлд гарган хүний хэрэгцээг хангах үйл ажиллагаа
 С. Хүмүүст аж ахуйг хэрхэн удирдах талаар онолын цэгцтэй мэдлэг олгодог шинжлэх ухаан
 D. Байгууллагын зорилгод хүрэх арга замуудыг төлөвлөн зохион байгуулж хэрэгжүүлэх үйл ажиллагаа
 E. Үйл ажиллагааг удирдан зангидах, зохион байгуулах урлаг
33. Аж ахуйн нэгжийн хувьд маркетинг ямар ач холбогдолтой болохыг илэрхийлсэн өгөгдөл аль нь вэ? /2 оноо/
 А. Зах зээлийн талаар илүү их мэдээлэлтэй болох В. Сонголт хийх илүү боломжтой болох
 С. Өрсөлдөгчөө таньж мэдэх D. Зардлаа багасгаж, цагаа хэмнэх
 E. Амьдралын хэв маягаа өөрчлөх
34. Дараах өгөгдлүүдээс гадаад худалдааг хязгаарлах бодлогын шалтгааныг олно уу. /1 оноо/
 А. Гадаад худалдааг хамгаалах В. Дотоодын хөгжиж буй салбаруудыг дэмжих
 С. Импортын барааг дэмжих D. Олон улсын худалдааг дэмжих
 E. Гадаад худалдааны бодлогод төр оролцох ёсгүй
35. Ажилгүйдлийн төрөл ангилалд аль нь хамаарахгүй вэ? /1 оноо/
 А. Шилжилтийн ажилгүйдэл
 В. Улирлын ажилгүйдэл
 С. Гэнэтийн ажилгүйдэл
 D. Бүтцийн ажилгүйдэл
 E. Мөчлөгийн ажилгүйдэл

36. Чөлөөт худалдааны бодлогыг аль нь тодорхойлж байна вэ? /2 оноо/
 А. Бусад улс орнуудтай тогтоосон худалдааны харилцааг зохицуулах зорилгоор төрөөс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний нийлбэр цогц
 В. Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор мөнгөний хэмжээ болон зээлийн хүүд нөлөөлөх бодлого
 С. Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор улсын орлого, зарлагыг өөрчлөх бодлого
 D. Дотоодын үйлдвэрлэлийг хамгаалж дэмжихийн тулд импортын барааны татварыг нэмэх юмуу импортод хязгаарлалт тогтоох бодлого
 E. Импортын татварыг бууруулж хязгаарлалтыг үгүй болгох бодлого
37. Олон улсын худалдаа болон үндэстэн хоорондын корпорацийн үйл ажиллагаа нь янз бүрийн орнуудын эдийн засгийг нягт холбож гадаад худалдаа болон эдийн засгийн бусад бодлогын талаар тодорхой зөвшилцөлд хүрэхийг эдийн засгийн гэнэ. /1 оноо/
 А. Өсөлт В. Харилцаа С. Интеграци D. Даяаршилт E. Хөгжил
38. Тогтвортой хөгжлийн тулгуур ойлголт аль нь вэ? /1 оноо/
 А. Байгаль орчин, эдийн засаг, нийгмийн байдал
 В. Наслалт, нялхсын эндэгдэл, бичиг үсэгт тайлагдалт
 С. Чөлөөтэй хөрвөх чадвар, хязгаарлагдмал хөрвөх чадвар
 D. Гаалийн татвар, хөнгөлөлт, хязгаарлалт
 E. Газар, хөдөлмөр, капитал
39. Хүний угсаа гарал, нас хүйс, арьс өнгө, нийгмийн статус, боловсрол, албан тушаал зэргээрээ ялгаварлагдалгүй хууль, шүүхийн өмнө нэгэн адил харилцах боломжийг гэнэ. /1 оноо/
 А. Дэг журам В. Тэгш эрх С. Эрх D. Эрх чөлөө E. Шударга ёс
40. Зөв харгалзуулна уу. /1 оноо/
 1. Амьдрах эрх А. Хүний угсаа гарал, нас хүйс, арьс өнгө, нийгмийн статус боловсрол, албан тушаал зэргээрээ ялгаварлагдалгүй хууль шүүхийн өмнө нэгэн адил харилцах боломж
 2. Эрх зүй В. Эрүүл аюулгүй орчинд хэвийн найдвартай аж төрөх боломж
 3. Тэгш эрх С. Хүний эрх, эрх чөлөөг ханган хамгаалж, нийгмийн олон талт амьдралд үйлчлэн зохицуулагч харилцааны систем
 А. 1b2c3a В. 1a2b3c С. 1c2a3b D. 1b2a3c E. 1a2c3b
41. Хууль болон төрийн бодлогыг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх ажлыг орон даяар, мөн орон нутгийн түвшинд зохион байгуулах нь..... -ны чиг үүрэг юм. /1 оноо/
 А. Төрийн үйлчилгээний алба В. Төрийн тусгай алба С. Төрийн захиргааны алба
 D. Улс төрийн алба E. Төрийн хамгаалалтын алба
42. Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээнд тавих шаардлагуудад хамааралгүй зүйл аль нь вэ? /1 оноо/
 А. Шударга байдалд суурилсан В. Сэтгэл ханамжинд суурилсан
 С. Ёс зүйд суурилсан D. Хариуцлагад суурилсан
 E. Соёлтой харилцаанд суурилсан
43. Олон нийтийн газар танхайрах, галт зэвсэг, хутга мэс авч явсан зэрэг тохиолдолд ямар төрлийн шийтгэл ногдуулах вэ? /2 оноо/
 А. Торгох В. Тусгайлан олгосон эрхийг хасах
 С. Хууль бусаар олсон орлого эд зүйлийг хураах D. Сануулга өгөх
 E. Баривчлах
44. Холбогдох утгатай нь зөв харгалзуулна уу. /1 оноо/
 1. Иргэн А. Тухайн улсын хуулийн дагуу иргэдийн биелүүлбэл зохих шаардлагуудын цогц
 2. Иргэний эрх В. Тухайн улсын хуулиар иргэддээ тогтоож өгсөн эрх, эрх чөлөө
 3. Иргэний үүрэг С. Тухайн улс орны хууль ёсны харьяалал бүхий хүн
 А. 1a2b3c В. 1c2a3b С. 1c2b3a D. 1a2c3b E. 1b2a3c
45. Хүн бүр эрхээ эдлэхэд саад учруулахгүй байх, төрийн зүгээс ялгаварлан гадуурхахгүй байх нь төрийн..... үүрэг юм. /1 оноо/
 А. Хүндэтгэх В. Албан тушаал ахиулах С. Хангах D. Хамгаалах E. Ахиц дэвшил гаргах

46. Иргэний нийгмийн байгууллагуудын хүний эрхийн чиглэлээр зохион байгуулдаг үйл ажиллагаанд хамаарахгүй өгөгдөл аль нь вэ? /2 оноо/
- A. Олон улсын гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих, засгийн газраас шаардах
 - B. Хүний эрх зөрчсөн тухай нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх
 - C. Хүний эрхийн асуудлаар судалгаа явуулах, мэдээллээр хангах
 - D. Хүний эрхийн боловсрол олгох
 - E. Эрх нь зөрчигдсөн хүмүүсийг хамгаалах үйлчилгээ үзүүлэх

47. Холбогдох утгатай нь зөв харгалзуулна уу. /1 оноо/

1.Эзэмших эрх	A. Эд юмсыг болон эрхийг хуулийн дагуу ашиглаж, түүнээс ашиг хонжоо олох,эсхүл ашиглан хэрэглэхийг хэлдэг
2.Ашиглах эрх	B. Эд юмсыг бусдад худалдах, өвлүүлэх,шилжүүлэх зэргээр өөрийн эрхийн хүрээнд бүрэн өмчлөх байдлыг хэлнэ.
3.Захиран зарцуулах эрх	C. Хүсэл зоригийн дагуу эрх, эд юмсыг хууль ёсоор мэдэлдээ байлгаж, арчлан хамгаалж байхыг хэлнэ.

A.1a2b3c B.1a2c3b C.1c2a3b D.1b2a3c E.1b2c3a

- 48.Төрийн үйлчилгээний албан тушаалтан аль нь вэ? /2 оноо/
- A. Монгол банкны ерөнхийлөгч
 - B. Улсын харьяаны их дээд болон ЕБС-ийн багш нар
 - C. Бүх шатны засаг дарга нар
 - D. Монгол Улсын их хурлын дарга, гишүүд
 - E. Сонгуулийн Ерөнхий Хорооны ажлын албаны албан тушаалтнууд

49. НҮБ-ийн гол байгууллагуудад орохгүй байгууллагыг олно уу. /1 оноо/
- A. Аюулгүйн зөвлөл
 - B. Асрамжийн зөвлөл
 - C. Олон улсын шүүх
 - D. Олон улсын валютын сан
 - E. Нарийн бичгийн дарга нарын газар

50. Аль нь НҮБ-ын албан ёсны хэл биш вэ? /1 оноо/
- A. Англи
 - B. Франц
 - C. Испани
 - D. Япон
 - E. Хятад

51. Зөв харгалзуулна уу. /1 оноо/

- | | |
|------------------------------------|--|
| 1. Олон улсын харилцааны туйл | A. Улс төрийн,эдийн засгийн, соёлын, шинжлэх ухаан, технологийн хүмүүнлэгийн зэрэг харилцаанууд багтдаг. |
| 2. Олон улсын харилцааны дэг журам | B. Дэлхийн улс орнуудын онцлог эрх, ашиг сонирхлыг уялдуулан зохицуулах горим бүхий тогтолцоо |
| 3. Олон улсын харилцааны хэлбэр | C. Дэлхийн үндэстэн улсуудын төр,засгийн харилцаанд шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд гол чухал шийдвэр гаргахад бодитой нөлөөлөгч улс орнууд |
- A.1a2b3c B.1c2b3a C.1a2c3b D.1c2a3b E.1b2a3c

52. Макро болон микро эдийн засгийн түвшний харилцааг хослуулсан, олон орны үндэсний аж ахуй хоорондын холбоо харилцааны цогцыг.....харилцаа гэнэ. /2 оноо/
- A. Олон улсын эдийн засгийн харилцаа
 - B. Олон улсын соёлын харилцаа
 - C. Олон улсын улс төрийн харилцаа
 - D. Олон улсын технологийн харилцаа
 - E. Олон улсын хүмүүнлэгийн харилцаа

53. Гадаад бодлогын үүрэгт хамааралгүй өгөгдөл аль нь вэ? /1 оноо/
- A. Батлан хамгаалах
 - B. Төлөөлөх мэдээлэх
 - C. Төрийн дотоод бодлогын үр дүнд нийгмийн бүх хэрэгцээг хангах
 - D. Хэлэлцээ хийх,зохион байгуулах
 - E. Төрийн гадаад харилцаа холбоог бий болгох

54. Монгол Японы харилцаа, хамтын ажиллагаа бүхий л салбарт өргөн хүрээг хамарч “Иж бүрэн түншлэл” –ийн дагуу хөгжиж байна. Энэ харилцаа нь Монгол улсын гадаад улс төрийн бодлогын аль чиглэлд хамаарах вэ? /2 оноо/
- A. Хөрш орнуудтай найрсаг тэнцвэртэй хамтын ажиллагааг хөгжүүлэх
 - B. Өрнө дорнын өндөр хөгжилтэй гүрнүүдтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх
 - C. Азийн бүс нутагт байр сууриа бататгах
 - D. НҮБ болон төрөлжсөн байгууллагуудтай хамтран ажиллах
 - E. Социалист хамтын нөхөрлөлийн гэгдэж байсан улсуудтай найрсаг харилцааг хөгжүүлэх

55. Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, харилцан биенийхээ төр ёсны уламжлал, шашин шүтлэгийг хүндэтгэж хандах, иргэдийнхээ ашиг сонирхлыг харилцан хамгаалах зэрэг нь олон улсын юм. /2 оноо/
 А. Эрх зүйн хариуцлага В. Эрх зүйн хэм хэмжээ С. Ёс зүйн хэм хэмжээ
 D. Ёс зүйн хариуцлага E. Харилцааны хэм хэмжээ
56. Ази номхон далайн бүсэд олон талын чөлөөт худалдааны хөрөнгө оруулалтын нээлттэй зах зээл бий болгох зорилготой байгууллага аль нь вэ? /1 оноо/
 А. АСЕАН В. АПЕК С. АСЕМ D. АРФ E. ШХАБ

ХОЁРДУГААР ХЭСЭГ

- Санамж: 1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож хариуг бөглөөрэй.
 2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1 Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу.

a	Валютын ханш	1	Төв банк өөрийн нөөцөөс зардал гарган валютыг худалдан авна.
b	Валютын хөвөгч ханш	2	Тухайн улсын валютын бусад орны валюттай солигдох чадвар
c	Валютын тогтмол ханш	3	Гадаадын нэгж валютыг өөрийн валютаар худалдан авах үнэ
d	Валютын интервенц	4	Гадаадын мөнгөний эрэлт, нийлүүлэлтээр тодорхойлогдож, ханш нь чөлөөтэй өсч, буурч байж болно.
e	Валютын хөрвөх чадвар	5	Чөлөөтэй өсч, буурдаггүй валютын ханш

2.2. Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу.

a	Төрийн үүрэг	1	Монгол улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс мөн.
b	Төрийн дотоод үүрэг	2	Монголын зэвсэгт хүчин олон улсын энхийг дэмжих үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байна.
c	Төрийн гадаад үүрэг	3	Тодорхой шаардлага хангасан албан хаагч хэрэгжүүлдэг
d	Төрийн хэлбэр	4	Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангах
e	Төрийн эрх мэдэл	5	Нийгмийн амьдралын хүрээнд төрөөс заавал гүйцэтгэх ёстой эрх зүйн болон зохион байгуулалтын үйл ажиллагааны үндсэн чиглэл

2.3. Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу.

a	Соёл	1	Бодит байдлыг уран сайхны дүрээр илэрхийлэх хэлбэр
b	Шинжлэх ухаан	2	Хүний мэдлэг, итгэл үнэмшил, ёс суртахуун, зан заншил болон бусад дадал чадварыг багтаасан цогц ойлголт
c	Урлаг	3	Нийгэмд хэм хэмжээний шинжтэй болж тогтож хэвшсэн нийтлэг ёс, журам
d	Шашин	4	Нотлогдож, шалгагдсан, үндэслэгээтэй, үнэн мэдлэгийг бүтээх зорилготой
e	Ёс суртахуун	5	Энэ ертөнц бол ер бусын хүчний бүтээл гэх үзэл

2.4. Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу.

a	Төрийн гүйцэтгэх засаглал	1	Улсын хил тогтоох, өршөөл үзүүлэх шийдвэр гаргах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
b	Төрийн захиргааны байгууллага	2	Төрийн шийдвэрийг гүйцэтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй засгийн газар, яам агентлагууд, нутгийн захиргааны байгууллагууд
c	Төрийн эрх барих, хууль тогтоох дээд байгууллага	3	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
d	Төрийн тэргүүн	4	Ерөнхий сайд, түүний танхимаас бүрдсэн засгийн газар
e	Нутаг дэвсгэр, засаг захиргааны өөрийн удирдлага	5	Монгол улсын харьяат болох, харьяатаас гарах асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.